

**БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГАД НЭР ДЭВШҮҮЛЭХ АСУУДЛААР ТӨРИЙН
БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНООС ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2013 оны 12 дугаар
сарын 25-ны өдөр

Улаанбаатар
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын
гишүүн Р.Гончигдорж**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн байгуулалтын байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх асуудлыг Байнгын хороо 2013 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд танилцуулж байна.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6., мөн хуулийн 22 дугаар зүйлийн 22.4., Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1. дэх хэсэгт заасныг баримтлан Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх асуудлыг хэлэлцлээ.


Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс Төрийн байгуулалтын байнгын хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Агипарын Бакейг улируулан ажиллуулахаар нэр дэвшүүлснийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтэй дэмжив.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Агипарын Бакейг Төрийн байгуулалтын байнгын хорооны даргаар сонгуулахаар нэр дэвшүүлсэн Байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА**



А.БАКЕЙ